

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/83/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsetseq.i@audit.mn">erdenetsetseq.i@audit.mn</a> Ахлах аудитор: Ш.Наран Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:naransh@audit.gov.mn">naransh@audit.gov.mn</a> Солид юнити аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох Утас: 99063227 Цахим хаяг: <a href="mailto:munkhtogtokh.e@solidunity.mn">munkhtogtokh.e@solidunity.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	1
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	1
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	2
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.5.3 Нэмэлт төсөв .....	13
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Албан шаардлага .....	20
5.2 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ССАЖЗЯ	Соёл спорт аялал жуулчлал, залуучуудын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙН  
ЗАХИРАЛ П.БАЙГАЛМАА ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/391

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсээс бусад зүйлсийн хувьд энэхүү санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 9,775.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- ТӨБЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 568 дугаар тогтоолоор Чингис хаан үндэсний музейд нийт 222 ширхэг хөрөнгийг 2024 онд балансаас балансад шилжүүлж данснаас хасахдаа дахин үнэлгээ хийгдсэн 367,612.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- Соёлын өвийн программд бүртгэлтэй хандиваар хүлээн авсан соёлын өвийн 3-н хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгээгүй;
- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 4 нэр төрлийн 637 ширхэг 314,897.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй;

- Дэлгүүрт зарагддаг бэлэг дурсгалын барааны орлого, зарлага, үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй;

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 15.2.7 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Сайдын 2025 оны А/61 тушаал "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллого хийх тухай" -аар музейн тооллогын комисс байгуулж, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллогыг 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, тооллогын үр дүн тайлант хугацааны эцэст 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 148,342.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс хуваарилсан хөрөнгө 54,960.0 мянган төгрөг, нийт 203,302.6 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого бүрдүүлж, 183,887.1 мянган төгрөгийг зарцуулж, 19,415.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Тайлант хугацаанд тус музейн үзэсгэлэнгийн танхимд нийт 21 үзэсгэлэн зохион байгуулснаас бие даасан чөлөөт уран бүтээлчдийн "Сэтгэлийн хэлхээс", "Цаг хугацаа үгүй", "Ул тасрах мөр", "Үзэсгэлэнт дөрвөн улирал", "Шүтээн торгон зураг", "Монгол шаазан 70 жил" мөн Урианхай Д.Тангадын 80 насны ойд зориулсан бүтээлийн чуулбар үзэсгэлэнгүүдийг төлбөртэй зохион байгуулж, 24,300.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Соёлын сайдын 2025 оны А/30, А/366 дугаар тушаал, 02/1955 тоот хамтран ажиллах албан тоотыг үндэслэн музейн захирлын 2025 оны А/12 тоот тушаалаар "Монгол нүүдэлчин" өвлийн фестивальд 10,000.0 мянган төгрөгийн зардал, А/58 тоот тушаалаар "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 22,800.0 мянган төгрөг, А/74 тоот тушаалаар "Монголын нэг өдөр" нүүдлийн үзэсгэлэнг 12,499.7 мянган төгрөгийн зардал гаргаж толилуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>81,496,050.72</b>	<b>132,210,083.36</b>
<b>31</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	-	-
31211	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
<b>33</b>	<b>Авлага</b>	<b>723,000.00</b>	<b>7,431,778.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	723,000.00	7,431,778.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	<b>30,500,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	-	30,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>80,773,050.72</b>	<b>94,278,305.36</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн /дэлгүүр/	-	3,277,773.02
35410	Бичиг хэргийн материал	1,913,691.42	176,000.00
35420	Аж ахуйн материал	68,333,715.39	84,159,727.48
35440	Түлш, шатах тослох материал	-	2,417,904.87
35470	Бусад хангамжийн материал	10,525,643.91	4,246,899.99
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,999,243,044.76</b>	<b>26,954,332,226.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>26,999,243,044.76</b>	<b>26,954,332,226.74</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>26,912,399,844.76</b>	<b>26,867,489,026.74</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,014,405,900.00	1,014,405,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(427,763,058.48)	(499,001,178.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,850,000.00	7,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,850,000.00)	(7,850,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж	349,877,035.76	389,662,035.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(242,502,407.39)	(270,365,430.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,842,879.52	132,530,365.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(97,978,936.65)	(94,725,448.33)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	26,164,175,500.00	26,164,175,500.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	25,263,504.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(11,353,153.18)
39217	Номын фонд	16,342,932.00	16,896,932.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>86,843,200.00</b>	<b>86,843,200.00</b>
39301	Программ хангамж	1,225,000.00	1,225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,225,000.00)	(1,225,000.00)
39305	Газар эзэмших эрх	86,843,200.00	86,843,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (3=1+2)</b>	<b>27,080,739,095.48</b>	<b>27,086,542,310.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>28,307,867.07</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>28,307,867.07</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>28,307,867.07</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	21,906,567.07
41361	Байгууллагад төлөх өглөг	-	6,401,300.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,080,739,095.48</b>	<b>27,058,234,443.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>2,372,812,225.00</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,372,812,225.00	2,372,812,225.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,372,812,225.00	2,372,812,225.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(588,177,086.34)</b>	<b>(610,681,738.79)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(431,672,008.39)	(588,177,086.34)
51220	Тайлант үеийн үр дүн	(156,505,077.95)	(22,504,652.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,296,103,956.82	25,296,103,956.82
<b>6</b>	<b>ӨМЧИЙН ДҮН (6=4+5)</b>	<b>27,080,739,095.48</b>	<b>27,086,542,310.10</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,306,877,653.79</b>	<b>1,384,876,370.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,172,811.79</b>	<b>4,143,715.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,172,811.79</b>	<b>4,143,715.70</b>
120009	Бусад орлого	2,371,811.79	1,023,715.70
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,801,000.00	3,120,000.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	-	<b>1,380,732,655.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	-	<b>1,380,732,655.00</b>
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,177,430,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,177,430,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	<b>203,302,555.00</b>
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	54,960,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	148,342,555.00
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,300,704,842.00</b>	-
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,099,062,200.00</b>	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,099,062,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>201,642,642.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,742,642.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,463,382,731.44</b>	<b>1,407,381,023.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,463,382,731.44</b>	<b>1,407,381,023.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,392,100,516.20</b>	<b>1,335,792,781.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>787,459,767.96</b>	<b>899,696,381.13</b>
210101	Үндсэн цалин	462,564,642.38	516,567,331.99
210102	Нэмэгдэл	156,473,484.32	149,381,744.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,972,433.76	142,631,000.00
210104	Урамшуулал	84,449,207.50	91,116,305.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>98,768,912.59</b>	<b>112,151,385.94</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,699,063.21	76,758,578.19
210202	Тэтгэмжийн даатгал	8,009,822.32	9,007,360.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,354,607.87	5,002,573.78
210204	Ажилгүйдлийн даатгал	3,941,023.81	4,267,360.48
210205	Эрүүл мэндийн даатгал	15,764,395.38	17,115,513.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,996,095.11</b>	<b>41,434,767.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,990,097.68	24,209,611.19

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	17,233,458.43	14,515,434.49
210303	Цэвэр, бохир ус	2,772,539.00	2,709,721.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,757,409.95</b>	<b>32,425,229.41</b>
210401	Бичиг хэрэг	5,962,640.02	4,895,591.42
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	2,651,161.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,631,856.59	2,913,724.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	656,013.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,006,900.34	20,524,751.92
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,299,938.00</b>	<b>893,000.00</b>
210604	Урсгал засвар	9,299,938.00	893,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,840,000.00</b>	<b>31,855,753.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	20,485,753.00
210702	Дотоод албан томилолт	5,840,000.00	11,370,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>124,496,367.00</b>	<b>79,154,391.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,038,800.00	71,576,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,752.00	247,456.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	129,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	624,300.00	1,438,300.00
210807	Газрын төлбөр	763,515.00	763,515.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>296,482,025.59</b>	<b>138,181,873.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,119,373.40	29,021,065.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,960,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,362,652.19	107,200,808.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>71,282,215.24</b>	<b>71,588,241.36</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>12,511,241.36</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>12,511,241.36</b>
<b>213112</b>	<b>Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал</b>	<b>-</b>	<b>12,511,241.36</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	47,475.83
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	12,463,765.53
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,833,444.14</b>	<b>59,077,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,168,200.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	30,552,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,613,244.14	57,977,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,448,771.10</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,564,326.69	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,884,444.41</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,884,441.41	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(156,505,077.65)</b>	<b>(22,504,652.45)</b>
<b>4</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(156,505,077.65)</b>	<b>(22,504,652.45)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,300,704,842.00</b>	<b>1,380,732,655.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,300,704,842.00</b>	<b>1,380,732,655.00</b>
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>1,300,704,842.00</b>	<b>1,380,732,655.00</b>
<b>12211</b>	<b>Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>	-	<b>1,177,430,100.00</b>
1221111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,177,430,100.00
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>203,302,555.00</b>
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	54,960,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	148,342,555.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,099,062,200.00</b>	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,099,062,200.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>201,642,642.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	135,742,642.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,249,602,842.00</b>	<b>1,326,429,665.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,249,602,842.00</b>	<b>1,326,429,665.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,178,320,626.46</b>	<b>1,240,821,645.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>787,459,767.96</b>	<b>879,263,400.00</b>
210101	Үндсэн цалин	474,198,242.56	469,798,508.33
210102	Нэмэгдэл	159,699,667.90	154,777,469.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,801,900.00	158,924,162.21
210104	Урамшуулал	77,759,957.50	95,763,259.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>99,491,912.59</b>	<b>109,954,800.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,422,063.21	75,446,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,009,822.32	8,627,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,354,607.87	4,313,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,941,023.81	4,313,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,764,395.38	17,254,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,624,283.32</b>	<b>41,434,767.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,990,097.68	24,209,611.19
210302	Түлш, халаалт	14,861,646.64	14,515,434.49
210303	Цэвэр, бохир ус	2,772,539.00	2,709,721.72
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,733,439.59</b>	<b>15,010,284.24</b>

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	3,899,800.00	2,537,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,631,856.59	2,793,724.24
210404	Ном, хэвлэл	-	2,655,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	656,013.00	960,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,045,770.00	4,064,060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,299,938.00</b>	<b>2,723,600.00</b>
210604	Урсгал засвар	9,299,938.00	2,723,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,840,000.00</b>	<b>20,485,753.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	20,485,753.00
210702	Дотоод албан томилолт	5,840,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>218,871,285.00</b>	<b>138,449,541.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	215,413,718.00	137,086,026.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,752.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	624,300.00	600,000.00
210807	Газрын төлбөр	763,515.00	763,515.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>33,499,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	33,499,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>71,282,215.54</b>	<b>85,608,019.36</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	<b>19,943,019.36</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	47,475.83
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	12,463,765.53
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	480,000.00
2131126	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	6,951,778.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,833,444.44</b>	<b>65,665,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,168,200.00	6,588,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	30,552,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	11,613,244.44	57,977,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,448,771.10</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,448,771.10	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>51,102,000.00</b>	<b>54,302,990.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>51,102,000.00</b>	<b>54,302,990.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>51,102,000.00</b>	<b>54,302,990.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	51,102,000.00	54,302,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,102,000.00	54,302,990.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(51,102,000.00)</b>	<b>(54,302,990.00)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
<b>C01</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,296,103,956.82</b>	<b>(431,672,008.69)</b>	<b>27,237,244,173.13</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
<b>C03</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,296,103,956.82</b>	<b>(431,672,008.69)</b>	<b>27,237,244,173.13</b>
C04	Тайлант үеийн үр дүн	-	-	(156,505,077.65)	(156,505,077.65)
<b>C05</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,296,103,956.82</b>	<b>(588,177,086.34)</b>	<b>27,080,739,095.48</b>
D06	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
<b>C07</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,296,103,956.82</b>	<b>(588,177,086.34)</b>	<b>27,080,739,095.48</b>
C08	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-
D09	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,504,652.45)	(22,504,652.45)
<b>D10</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,296,103,956.82</b>	<b>(610,681,738.79)</b>	<b>27,058,234,443.03</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,209,121,000.00</b>	<b>1,177,382,624.17</b>	<b>31,738,375.83</b>	<b>97.4</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,209,121,000.00</b>	<b>1,177,382,624.17</b>	<b>31,738,375.83</b>	<b>97.4</b>
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>1,209,121,000.00</b>	<b>1,177,382,624.17</b>	<b>31,738,375.83</b>	<b>97.4</b>
122005	Төсвөөс санхүүжих орлого	1,209,121,000.00	1,177,382,624.17	31,738,375.83	97.4
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,209,121,000.00</b>	<b>1,176,902,624.17</b>	<b>32,218,375.83</b>	<b>97.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,209,121,000.00</b>	<b>1,176,902,624.17</b>	<b>32,218,375.83</b>	<b>97.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,132,101,200.00</b>	<b>1,112,337,624.17</b>	<b>19,763,575.83</b>	<b>98.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>879,263,400.00</b>	<b>879,263,400.00</b>	-	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	471,386,200.00	469,798,508.33	1,587,691.67	99.7
210102	Нэмэгдэл	151,294,300.00	154,777,469.99	(3,483,169.99)	102.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,819,500.00	158,924,162.21	1,895,337.79	98.8
210104	Урамшуулал	95,763,400.00	95,763,259.47	140.53	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>109,954,800.00</b>	<b>109,954,800.00</b>	-	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	75,446,400.00	75,446,400.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,627,000.00	8,627,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,313,600.00	4,313,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,313,600.00	4,313,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,254,200.00	17,254,200.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,850,600.00</b>	<b>38,323,809.17</b>	<b>526,790.83</b>	<b>98.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,922,700.00	21,240,352.96	1,682,347.04	92.7
210302	Түлш, халаалт	13,267,500.00	14,373,734.49	(1,106,234.49)	108.3
210303	Цэвэр, бохир ус	2,660,400.00	2,709,721.72	(49,321.72)	101.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,572,400.00</b>	<b>1,405,820.00</b>	<b>1,166,580.00</b>	<b>54.7</b>
210401	Бичиг хэрэг	299,200.00	156,000.00	143,200.00	52.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	538,800.00	505,300.00	33,500.00	93.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	538,300.00	240,000.00	298,300.00	44.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,196,100.00	504,520.00	691,580.00	42.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>50,780,700.00</b>	<b>42,290,000.00</b>	<b>8,490,700.00</b>	<b>83.3</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,780,700.00	42,290,000.00	8,490,700.00	83.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,593,800.00</b>	<b>7,600,295.00</b>	<b>4,993,505.00</b>	<b>60.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,836,800.00	6,836,780.00	20.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	4,977,100.00	0.0
210807	Газрын төлбөр	779,900.00	763,515.00	16,385.00	97.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,085,500.00</b>	<b>33,499,500.00</b>	<b>4,586,000.00</b>	<b>88.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,085,500.00	33,499,500.00	4,586,000.00	88.0

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>77,019,800.00</b>	<b>64,565,000.00</b>	<b>12,454,800.00</b>	<b>83.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>77,019,800.00</b>	<b>64,565,000.00</b>	<b>12,454,800.00</b>	<b>83.8</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,042,800.00	6,588,000.00	12,454,800.00	34.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,977,000.00	57,977,000.00	-	100.0
<b>3</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	<b>480,000.00</b>	<b>(480,000.00)</b>	<b>(100.0)</b>
4	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(480,000.00)	480,000.00	(100.0)
5	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(480,000.00)	480,000.00	(100.0)
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1</b>	<b>1</b>	-	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	-	<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>29</b>	<b>29</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9	9	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>203,302,555.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>203,302,555.00</b>
<b>1311</b>	<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>203,302,555.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,960,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	148,342,555.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>183,887,011.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>183,887,011.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>182,787,011.47</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>3,110,958.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,969,258.23
210302	Түлш, халаалт	141,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,604,464.24</b>
210401	Бичиг хэрэг	2,381,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,288,424.24
210404	Ном, хэвлэл	2,655,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,559,540.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,723,600.00</b>
210604	Урсгал засвар	2,723,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,485,753.00</b>
210701	Гадаад албан томилолт	20,485,753.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>142,862,236.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,262,236.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,100,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,100,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00
<b>3</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>19,415,543.53</b>
<b>4</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(19,415,543.53)</b>
<b>5</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(19,415,543.53)</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дүрслэх урлагийн музейн эрхэм зорилт нь “Монголын дүрслэх урлагийн зуун зууны шилдэг зураач, урчуудын сор, дахин давтагдашгүй үзмэр цуглуулгыг дотоод, гадаадын үзэгчдэд дэлгэн толилуулж, эрдэм шинжилгээ судалгааны болон урлагийн гоо зүйн мэдлэг мэдээллээр хангах үүрэг бүхий нийгэмд чиглэсэн соёл, гэгээрэл, судалгаа, аялал-танин мэдэхүйн үйлчилгээ үзүүлэхэд оршино”:

Эрхэм зорилтын хүрээнд Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей нь үндсэн чиглэл, үзэл баримтлалын хүрээнд соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжилж, нээн илрүүлэх, олж авах, үзмэрийг бүртгэн баримтжуулах, музейн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, үзүүлэн дэглэх, үйлчлэх, гадаад дотоодын үзэсгэлэн зохион байгуулах, боловсрол, танин мэдэхүйн ажил зохион байгуулах, сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, үр дүнг хэвлүүлэх, түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, үзмэрийг гадаад, дотоод үзэсгэлэнд оролцуулах, иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн соёлын дурсгалт зүйлийг түр хугацаагаар үзэсгэлэн, үзүүлэн дэглэх ашиглах, музей хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хуулиар хориглоогүй бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус музей нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд музейн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын үйл ажиллагаанд Соёл спорт аялал жуулчлал, залуучуудын яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавин ажилладаг бөгөөд тайлант оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дүрслэх урлагийн музей нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус музей нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт

бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогод хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон “Санхүүгийн тайлангийн заавар”, 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын хавсралт “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” зэрэг тушаалуудын зааварчилгаа мөн үндсэн хөрөнгийн дансны ангилалд тус байгууллагын онцлогт тохирсон өв сангийн ангилал тусгагдаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дүрслэх урлагийн музей 2025 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,803.2 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	-	-
Авлага	723.0	7,431.8	6,708.8
Урьдчилж гарсан зардал	-	30,500.0	30,500.0
Бараа материал	80,773.1	94,278.3	13,505.2
Үндсэн хөрөнгө	26,999,243.0	26,954,332.2	(44,910.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>27,080,739.1</b>	<b>27,086,542.3</b>	<b>5,803.2</b>
Өр төлбөр	-	28,307.8	28,307.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,372,812.2	2,372,812.2	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөл/бууралт	25,296,104.0	25,296,104.0	-
Хуримтлагдсан үр дүн	(588,177.1)	(610,681.7)	(22,504.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>27,080,739.1</b>	<b>27,086,542.3</b>	<b>5,803.2</b>

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данстууд байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 30,500.0 мянган төгрөг болж өссөн нь Соёл спорт аялал жуулчлал, залуучуудын яамны сайдын А/32 тоот тушаалын дагуу 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 04/01 тоот "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ"-ний дагуу төлсөн урьдчилгаа төлбөр, мөн Монгол улсын их сургуулийн “Нүүдэлчдийн археологийн хүрээлэн”-тэй байгуулсан 2025 оны 6-р сарын 06-ны өдрийн 03/08 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-ний хүчин төгөлдөр байх хугацаа 3 жил бөгөөд уг гэрээнд "Талууд Монгол нутагт археологийн хайгуул, малтлага судалгаа, эрдэм шинжилгээ судалгааны ажлуудад хамтран ажиллах, илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнийг музейн сан хөмрөг, үзмэрийг баяжуулах, нийтийн хүртээл болгох, судалгааны үр дүнг хэвлэн нийтлэх, үзмэр эд өлгийн зүйлсийг сэргээн засварлах чиглэлээр хамтран ажиллах" гэж заасны дагуу тайлант онд судалгаа малтлагын ажлын төлбөрт төлсөн урьдчилгаа төлбөрүүд байна;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 26,954,332.2 мянган төгрөг болж 44,910.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд шинээр 62,290.0 мянган төгрөгийн үндсэн

хөрөнгө худалдан авч 107,200.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож бүртгэснээс тус тус шалтгаалсан;

- Өр төлбөр данс нь 28,307.8 мянган төгрөг болж өссөн нь тайлант хугацаанд хувь хүний орлогын албан татварын өр 21,781.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 125.2 мянган төгрөг, аудитын үйлчилгээний төлбөр 5,000.0 мянган төгрөг, хог хаягдлын төлбөр 480.0 мянган төгрөг, хэвлэлийн үйлчилгээний төлбөр 921.3 мянган төгрөгийн өр төлбөрийг тус тус төлөөгүйтэй холбоотой байна.

Дүрслэх урлагийн музей нь санхүү, нягтлан бодох бүртгэлдээ Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Acolous 4.0 программ ашиглаж байна. Тус программд тухай бүр шинэчлэлт хийгддэг. Төсвийн байгууллагын бүх шаардлагатай мэдээ тайланг боловсруулж гаргадаг. Төрийн сангийн удирдлагын нэгдсэн систем, цалингийн нэгдсэн системтэй шууд холбогдож байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,298,831.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 160,848.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,137,982.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ төсвийн төслийг батлахдаа Улсын их хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан 2025 оны төсвийн тухай хуулийн хүрээнд, төрийн хэмнэлтийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон Улсын их хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолыг үндэслэсэн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 71,138.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг 1,209,121.0 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,177,382.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,176,902.6 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь эд хогшил, урсгал засварын зардлыг 8,490.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 4,993.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,586.0 мянган төгрөг, бусад урсгал зардлыг 12,454.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 1,166.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 526.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, 47.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 480.0 мянган төгрөгийг буцаан авахаар байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

	Хөтөлбөр, арга хэмжээ	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Соёл урлаг	71706	1,209,121.0	1,176,902.6	32,218.4	97.3
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	80101	1,017,355.5	1,011,196.1	6,159.4	99.4
1.2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	80215	1,757.4	1,757.4	-	100.0
1.3	Харуул, хамгаалалтын зардал	80219	3,591.8	3,591.8	-	100.0
1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	81802	57,977.0	57,977.0	-	100.0

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1.5	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	81569	270.0	270.0	-	100.0
1.6	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	81855	126,951.7	100,892.7	26,059.0	79.5
1.7	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	81908	1,217.6	1,217.6	-	100.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

- Төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээний хүрээнд ССАЖЗЯ-нд 2025 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 25/122 тоот “Орон тоо, бүтэц батлуулах зөвшөөрөл хүсэх тухай албан бичиг хүргүүлсэн. Тус албан бичгээр 3 албан хаагчийн /жолооч, тайлбарлагч, шинжээч/ сул орон тоонд ажилтан авахгүй царцаасан байна.
- Тайлант онд тус музейн захирал Америкийн нэгдсэн улсад “Монгол нийгэмлэг”-ийн 64 дэх удаагийн монгол судлалын хурал, Индианполис хотын Индианангийн их сургуулийн Херрон урлаг, дизайны сургуультай 2028 онд зохион байгуулагдах уламжлалт урлаг дээр суурилсан орчин үеийн уран бүтээлчдийн хамтарсан үзэсгэлэнг зохион байгуулах, Вашингтон хот дахь Азийн урлагийн музей, Нью Йорк хот дахь Метрополитан, Сан Франциско хот дахь Азийн урлагийн музейн удирдлагуудтай уулзан өөрийн музейн танилцуулгыг хийх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор өөрийн үйл ажиллагааны орлогоос 20,485.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Тайлант онд Улаанбаатар Худалдаа Хангамжийн Нэгдэл ХХК-тай байгуулсан 06/02 тоот гэрээгээр “Өндөр гэгээний гаран дардасны уут шошготой хэвлэл” 500 ширхэг 11,250.0 мянган төгрөг, Аксиллион ХХК-тай байгуулсан 06/01 тоот гэрээгээр “Өндөр гэгээний гарын дардасны торгон дээрх хэвлэл” 500 ширхэг нийт 18,750.0 мянган төгрөг, Сэлэнгэ пресс ХХК-тай байгуулсан 02/18 тоот гэрээгээр “Баримт бичгийн эмхэтгэл” 300 ширхэг нийт 9,741.0 мянган төгрөг, мөн ширээний календарь 300 ширхэг нийт 5,544.0 мянган төгрөг, Талст Дизайн ХХК-тай байгуулсан 02/04 тоот гэрээгээр “Монгол өвлийн нүүдэлчин фестиваль”-ийн хэвлэл, 02/15 тоот гэрээгээр “Нүүдэлчин фестиваль”-д зориулсан хэвлэлүүд нийт 3,500.0 мянган төгрөг, Арилдал ХХК-иар 7000 ширхэг нийт 616.0 мянган төгрөгийн тасалбар тус тус хэвлүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 148,342.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 54,960.0 мянган төгрөг нийт 203,302.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3,111.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 13,604.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2,723.6 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 20,485.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 142,862.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг зардалд 1,100.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 19,415.5 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчид буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус музей нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж харьяа дээд байгууллагаар батлуулаагүй, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй мөн тайлант онд 53,749.0 мянган төгрөгийн хэвлэлийн үйлчилгээ, 53,715.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сонгон шалгаруулалт хийлгүй шууд худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Дүрслэх урлагийн музей, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн музейн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн ажилтанд олгох нэг удаагийн тэтгэмжийг зөв тооцоолж олгох, үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлэх, үндсэн хөрөнгийн дансанд “0” өртөгтэй хандиваар хүлээн авсан хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр бүртгэх, байгууллагынхаа үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Солид юнити аудит ХХК-ийн ахлах аудитор Ү.Цэцэгмаа, аудиторын туслах Э.Нямдорж, Ч.Хүслэн нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Н.Тунгалаг, гүйцэтгэх захирал Э.Мөнхтогтох нар хэрэгжүүлж, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Дүрслэх урлагийн музей нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Солид юнити аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 26/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,463,382.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,633.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон тайлант оны нийт зардлын дүн өмнөх оны дүнгээс 66,953.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлт нийт зардлын 1,396,429.5 мянган төгрөгөөс шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувь буюу 9,775.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан заалтын хүрээнд хэмнэлтийн зарчим баримталж байгууллага бүтэц орон тоог нэмэгдүүлээгүй, хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 436,862.1 мянган төгрөгийн зөрчлөөс 107,463.8 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 329,398.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дүрслэх урлагийн музей нь 2025 онд нийт 1,597,692.9 мянган төгрөгийн 53 гүйлгээний мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 35,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг, орлогын 257,285.9 мянган төгрөгийн 10 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн. Мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 15 харилцагчийн 176,351.5 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээнээс 5,256.5 мянган төгрөгийн 1 худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тайлант онд батлагдсан төсөвт тусгагдаагүй гадаад болон дотоод томилолтод нийт 31,855.8 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2. Тус байгууллага тайлант онд 53,748.9 мянган төгрөгийн хэвлэлийн үйлчилгээ, 53,715.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сонгон шалгаруулалт хийлгүй шууд худалдан авсан байна. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж харьяа дээд байгууллагаар батлуулаагүй, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д “захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “захиалагч батлагдсан төсөвт

туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 44.3-т “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ”, 46 дугаар зүйлийн 46-д “захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана” гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт хийлгүй худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан харьяа дээд байгууллагаар батлуулаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй ажиллах хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3. Тус байгууллагад мөрдөгдөж буй НБББББ нь Соёлын сайдын 2022 оны 01-р сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан бодлого бөгөөд тус бодлогод хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам", Сангийн Сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон “Санхүүгийн тайлангийн заавар” зэрэг тушаалуудын зааварчилгаа мөн үндсэн хөрөнгийн дансны ангилалд тус байгууллагын онцлогт тохирсон өв сангийн ангилал тусгагдаагүй зэргээс үзэхэд холбогдох бодлогын бичиг нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллага өөрийн нөөц боломжийг ашиглан, төсвөөс зардал гаргахгүй өөрийн байгууллагын онцлогт тохирсон НБББББ-ийг боловсруулж батлуулан, дагаж мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж хөрөнгө болон өр төлбөр, орлого болон зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар нийт 555,567.4 мянган төгрөгийн 18 алдаа, зөрчил илэрснээс 71,329.1 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 484,238.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн. Завсрын аудитаар илэрсэн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах тухай асуудал, бараа материалын тооллого, үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг хувь хүний данстай холбосон банкны пос машинаар уншуулан авч төрийн сангийн дансанд хугацаа хоцроон тушааж байсан зэрэг зөрчлүүд хэрэгжээгүй тул жилийн эцсийн аудитын тайланд тусгаж албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 51,102.0 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс зөрчлийг давтан гаргахгүй байх 51,102.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	51,102.0	-	-	0.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>51,102.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй тул тайлант онд хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дүрслэх урлагийн музейн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тооллогын үр дүн мөн балансаас балансад шилжүүлэн данснаас хассан хөрөнгөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийн бүртгэл, хандиваар ирсэн соёлын өвийн 3-н хөрөнгийн бодит үнэ цэнийн бүртгэлийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 219,155.7 мянган төгрөгийн 13 алдааг санхүүгийн тайланд залруулга хийсэн. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Завсрын аудитаар өгсөн шатахууны зардал 3,231.0 мянган төгрөгийн залруулгыг алдаатай бүртгэснээс өмнөх үеийн үр дүн болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа дансанд тус тус нөлөөлснийг залруулсан;
- Дэлгүүрийн барааны үлдэгдэл 3,277.8 мянган төгрөгийн барааг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэснийг залруулсан;
- Тайлант хугацааны шатахууны зардал 295.2 мянган төгрөгийг өмнөх үр дүн дансанд бүртгэснийг залруулсан;
- Тайлант хугацаанд тэтгэвэрт гарсан ажилтны цалингаас тооцсон шимтгэлийн хувийг нийгмийн даатгалын тайланд буруу тайлагнаж 289.1 мянган төгрөгийн өглөгийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад өгөх өглөгөөр бүртгээгүйг залруулан бүртгэсэн;
- "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" гэрээний биелэлт дүгнээгүй гэрээнд заасан ажлын тайлан мэдээг аваагүй, нотлох баримт бүрдэлгүйгээр шууд зардалд бүртгэсэн 15,500.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд залруулан бүртгэсэн.
- "Хамтын ажиллагааны гэрээ"-ний үргэлжлэх хугацаа 3 жил бөгөөд тайлант онд тус судалгаа малтлагын ажилд зарцуулсан 15,000.0 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэснийг урьдчилж төлсөн зардал дансанд залруулан бүртгэсэн;
- Тайлант хугацааны 6-12 сарын элэгдлийн зардал 50,622.1 мянган төгрөгийг дутуу бүртгэснийг залруулсан;
- Төсөвт байгууллагын өөрийн үндсэн үйл ажиллагаанаас олсон үзэсгэлэнгийн болон тасалбарын орлого 28,685.8 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө дансанд бүртгэснийг залруулан бүртгэсэн;
- Зардлын эдийн засгийн ангиллыг 57,251.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг залруулсан;
- Бараа материалын дансанд 4,867.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэснийг залруулсан;
- 31,749.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэснийг залруулсан;
- Банкны пос машины шимтгэлийн зардал 954.6 мянган төгрөгийг дутуу бүртгэснийг залруулсан.
- Сангийн сайдын "Дансны үлдэгдэл буцаах" тушаалын дагуу 7,431.8 мянган төгрөгийг авлагаар залруулсан.

Дээрх алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4, 6 дугаар зүйл, 6.1, 15.2, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 тоот тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 "Бараа материал", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" стандартууд, санхүүгийн тайлагналын тасалбар болголт, ангилал, толилуулга, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 825,690.0 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 138,563.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, зөрчлийн цаашид давтан гаргахгүй ажиллах 687,126.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 825,690.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 815,915.0 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

## 5.1 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант оны хагас жилээр бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, мөн дэлгүүрт борлуулах нийт 83,661.3 мянган төгрөгийн бэлэг дурсгалын барааны орлого, зарлага, үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, дэлгүүрийн бараанд бүртгэлээр хяналт тавьдаггүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2.1-д "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ, Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичигт "Бараа материалын нэгдсэн тооллогыг хагас, бүтэн жилээр байгууллагын гүйцэтгэх удирдлагын тушаалаар томилогдсон тооллогын комиссын гишүүд хийж гүйцэтгэнэ. Мөн шаардлагатай тохиолдолд гэнэтийн тооллогыг хийнэ. Тооллогыг хийж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор хариуцсан нягтлан бодогч тооцоог бодож, тооллогын комисст хүлээлгэж өгөх ба комисс тооллогын үр дүнг гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нарт танилцуулна" гэж заасан заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, дэлгүүрийн барааны орлого, зарлага, үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тус байгууллага тайлант хугацаанд өөрийн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого болох музейн үзмэрийн тасалбарын орлого болон бэлэг дурсгалын зүйлс худалдан борлуулсны орлого нийт 54,902.5 мянган төгрөгийг кассын ажилтны нэр дээр бүртгэлтэй Голомт банк болон Төрийн банкны данстай холбосон пос машинаар уншуулан авч тус орлогыг Төрийн сангийн дансанд 14-21 хоногт мөн сар дамжуулан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна", 35.6-д "Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран батална" мөн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 2 дугаар бүлэг "Бэлэн мөнгөний кассын ажиллагаа"-ны 2.6-д "Төсөвт байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэж заасан заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг хувь хүний дансаар дамжуулан авч Төрийн сангийн дансанд цаг тухай бүрт төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

## 5.2 Зөвлөмж

### 1. Тэтгэвэр тогтоолгосон ажилтны тэтгэмжтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тус байгууллага тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэр тогтоолгож, ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо 4,616.6 мянган төгрөгийг дутуу тооцоолж олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д "Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна" гэж заасан заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид хуульд заасан хугацааг үндэслэн үнэн зөв тооцож олгож байх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

## **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 4 нэр төрлийн 637 ширхэг 314,897.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 онд баталсан "Журам шинэчлэх тухай" 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засан сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ." мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр тайлагнах, ашиглах хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ- хүргүүлж, шийдвэрлүүлэх.

## **3. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: ТӨБЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 568 дугаар тогтоолоор музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй түүх соёлын дурсгалт зүйлсийн хөрөнгөөс Чингис хаан үндэсний музейд нийт 222 ширхэг 609,785.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх шийдвэрийн дагуу тус байгууллага 2024 онд балансаас хасахдаа дахин үнэлгээ хийгдсэн 367,612.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-н 2019 оны 271 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйлийн 9.1-д "Эрх бүхий байгууллагын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу данс бүртгэлд тусгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгүүдийн дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгэх.

## **4. Бодит үнэ цэнээр илэрхийлээгүй соёлын өвийн хөрөнгүүдтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Аудитаар санхүүгийн байдлын тайланд тусгасан өвийн хөрөнгийн үлдэгдлийг Соёлын өвийн үндэсний төвийн дэд системийн үлдэгдэлтэй тулган шалгахад 2024 онд хандиваар ирсэн 2 хөрөнгө, гаалийн газраас ирсэн 1 хөрөнгө нийт 3-н нэр төрлийн хөрөнгө "0" өртөгтэй бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/3 тушаалын 10 дугаар хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Завсрын аудитаар өгсөн залруулгыг алдаатай бүртгэсэн.	1	3,231.0					1	3,231.0				
Дэлгүүрийн барааны үлдэгдлийг зардалд бүртгэсэн.	1	3,277.8					1	3,277.8				
Тайлант хугацааны зардлыг өмнөх үеийн үр дүнд бүртгэсэн.	1	295.2					1	295.2				
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад өгөх өглөг бүртгээгүй.	1	289.1					1	289.1				
"Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ"-ний биелэлтийг дүгнээгүй шууд зардалд бүртгэсэн.	1	15,500.0					1	15,500.0				
3-н жилийн хугацаатай гэрээний тайлант онд зарцуулсан төлбөрийг шууд зардалд бүртгэсэн.	1	15,000.0					1	15,000.0				
Тайлант хугацааны 6-12 сарын элэгдлийн зардал дутуу бүртгэсэн.	1	50,622.1					1	50,622.1				
Өөрийн орлогыг дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлогоор бүртгэсэн.	1	28,685.8					1	28,685.8				
Зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүтэй бүртгэсэн.	1	57,251.4					1	57,251.4				
Үндсэн хөрөнгүүдийг бараа материалын дансанд бүртгэсэн.	1	4,867.0					1	4,867.0				
Үндсэн хөрөнгийн ангилал зөрүүлэн бүртгэсэн.	1	31,749.7					1	31,749.7				
Банкны пос машины шимтгэлийн зардлыг дутуу бүртгэсэн.	1	954.6					1	954.6				
Сангийн сайдын "Дансны үлдэгдэл буцаах" тушаалын дагуу авлага үүсгээгүй.	1	7,431.8					1	7,431.8				
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>219,155.7</b>					<b>13</b>	<b>219,155.7</b>				

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтнуудад нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо дутуу тооцоолж олгосон.	1	4,616.6					1	4,616.6				
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа 4 нэр төрлийн 637 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	1	314,897.6					1	314,897.6				
Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн нөөцийн хэрэгжилтийг үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй	1	367,612.0					1	367,612.0				
2024 онд хандиваар ирсэн 2 хөрөнгө, гаалийн газраас ирсэн 1 хөрөнгө нийт 3-н нэр төрлийн хөрөнгө "0" өртөгтэй бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй.	1	-					1	-				
Тайлант оны хагас жилээр бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, мөн дэлгүүрт борлуулах нийт 83,661.3 мянган төгрөгийн барааны орлого, зарлага, үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, дэлгүүрийн бараанд бүртгэлээр хяналт тавьдаггүй.	1	83,661.3			1	83,661.3						
Тайлант хугацаанд өөрийн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого болох музейн	1	54,902.5			1	54,902.5						

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үзмэрийн тасалбарын орлого болон бэлэг дурсгалын зүйлс худалдан борлуулсны орлогыг кассын ажилтны нэр дээр бүртгэлтэй Голомт банк болон Төрийн банкны данстай холбосон пос машинаар уншуулан авч тус орлогыг Төрийн сангийн дансанд 14-21 хоногт мөн сар дамжуулан төвлөрүүлсэн байна												
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>825,690.0</b>			<b>2</b>	<b>138,563.8</b>	<b>4</b>	<b>687.126.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Шилэн дансны цахим хуудсанд нийт 1,597,692.9 мянган төгрөгийн 53 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 35,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг, орлогын 257,285.9 мянган төгрөгийн 10 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн. мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 15 харилцагчийн 176,351.5 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээнээс 5,256.5 мянган төгрөгийн 1 худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй байна.	1	297,542.4	1	297,542.4		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>297,542.4</b>	<b>1</b>	<b>297,542.4</b>		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Тайлант онд батлагдсан төсөвт тусгагдаагүй гадаад болон дотоод томилолтод нийт 31,855.8 төгрөгийг зарцуулсан байна	1	31,855.8	1	31,855.8		
Тус байгууллага тайлант онд 53,748.9 мянган төгрөгийн хэвлэлийн үйлчилгээ, 53,715.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сонгон шалгаруулалт хийлгүй шууд худалдан авсан байна. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж харьяа дээд байгууллагаар батлуулаагүй, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.	1	107,463.9	1	107,463.9		
Тус байгууллагад мөрдөгдөж буй НБББББ нь Соёлын сайдын 2022 оны 01-р сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан бодлого бөгөөд тус бодлогод хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын хавсралт	1	-			1	-

Дүрслэх урлагийн музейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

"Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам", Сангийн Сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" болон "Санхүүгийн тайлангийн заавар" зэрэг тушаалуудын зааварчилгаа мөн үндсэн хөрөнгийн дансны ангилалд тус байгууллагын онцлогт тохирсон өв сангийн ангилал тусгагдаагүй зэргээс үзэхэд холбогдох бодлогын бичиг нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>139,319.7</b>	<b>2</b>	<b>139,319.7</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>436,862.1</b>	<b>3</b>	<b>436,862.1</b>	<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 164/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/83/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дүрслэх Урлагийн Музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага тайлант хугацаанд өөрийн үндсэн үйл ажиллагаанаас олсон орлого болох музейн үзмэрийн тасалбарын орлого болон бэлэг дурсгалын зүйлс худалдан борлуулсаны орлого нийт 54,902,464.21 (тавин дөрвөн сая есэн зуун хоёр мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг хорин нэгэн мөнгө)-ийг кассын ажилтны нэр дээр бүртгэлтэй Голомт банк болон Төрийн банкны данстай холбосон пос машинаар уншуулан авч тус орлогыг Төрийн сангийн дансанд 14-21 хоног болон сар дамжуулан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна", 35.6-д "Төсвийн байгууллага төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур банкинд данс нээх, түүнийг хаахтай холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран батална", мөн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 2 дугаар бүлэг "Бэлэн мөнгөний кассын ажиллагаа"-ны 2.6-д "Төсөвт байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг хувь хүний дансаар дамжуулан авч Төрийн санд цаг тухай бүрт төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дүрслэх Урлагийн Музейн Захирал (П.Байгалмаа), Ерөнхий нягтлан бодогч (Н.Мөнхзул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 165/АД150122

Улаанбаатар хот

САГ - 2026/83/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дүрслэх Урлагийн Музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын нийт 1,597,692,893.00 (нэг тэрбум таван зуун ерэн долоон сая зургаан зуун ерэн хоёр мянга найман зуун ерэн гурван) төгрөгийн 53 гүйлгээний мэдээлэл ил тод байршуулахаас зарлагын 35,000,000.00 (гучин таван сая) төгрөгийн 2 гүйлгээг, орлогын 257,285,900.0 (хоёр зуун тавин долоон сая хоёр зуун наян таван мянга есөн зуун) төгрөгийн 10 гүйлгээг, хугацаа хоцроон мэдээллэсэн мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 15 харилцагчийн 176,351,508.72 (нэг зуун далан зургаан сая гурван зуун тавин нэгэн мянга таван зуун найман төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн мянган төгрөгийн худалдан авалтаас 5,256,500.00 (таван сая хоёр зуун тавин зургаан мянга таван зуун) төгрөгийн 1 худалдан авалтын гүйлгээг мэдээллээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дүрслэх Урлагийн Музейн Захирал (П.Байгалмаа), Ерөнхий нягтлан бодогч (Н.Мөнхзул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Э.МӨНХТОГТОХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

АТА1087  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-29.Docx

1526180541



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 166/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/83/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дүрслэх Урлагийн Музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд батлагдсан төсөвт тусгагдаагүй гадаад болон дотоод томилолтод нийт 31,855,753.00 (гучин нэгэн сая найман зуун тавин мянга долоон зуун тавин гурван) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт тусгагдаагүй зардлыг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дүрслэх Урлагийн Музейн Захирал (П.Байгалмаа), Ерөнхий нягтлан бодогч (Н.Мөнхзул) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Э.МӨНХТОГТОХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 167/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/83/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дүрслэх Урлагийн Музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага тайлант оны хагас жилээр бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, мөн дэлгүүрт борлуулах нийт 83,661,327.00 (наян гурван сая зургаан зуун жаран нэгэн мянга гурван зуун хорин долоон) төгрөгийн барааны орлого, зарлага, үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, дэлгүүрийн бараанд бүртгэлээр хяналт тавьдаггүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т. Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичигт "Бараа материалын нэгдсэн тооллогыг хагас, бүтэн жилээр байгууллагын гүйцэтгэх удирдлагын тушаалаар томилогдсон тооллогын комиссын гишүүд хийж гүйцэтгэнэ. Мөн шаардлагатай тохиолдолд гэнэтийн тооллогыг хийнэ. Тооллогыг хийж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор хариуцсан нягтлан бодогч тооцоог бодож, тооллогын комисст хүлээлгэж өгөх ба комисс тооллогын үр дүнг гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нарт танилцуулна" гэж заасан заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2-т "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулдаггүй, дэлгүүрийн барааны орлого, зарлага, үлдэгдлийн хураангуй болон дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, үлдэгдлийг тоолж баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дүрслэх Урлагийн Музейн Захирал (П.Байгалмаа), Ерөнхий нягтлан бодогч (Н.Мөнхзул) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Э.МӨНХТОГТОХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-29.Docx

1526180545



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 168/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/83/НА - СТА - ТИЗ

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дүрслэх Урлагийн Музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага тайлант онд 53,748,990.00 (тавин гурван сая долоон зуун дөчин найман мянга есөн зуун ерэн) төгрөгийн хэвлэлийн үйлчилгээ, 53,715,000.00 (тавин гурван сая долоон зуун арван таван мянган) төгрөгийн үндсэн хөрөнгийг сонгон шалгаруулалт хийлгүй шууд худалдан авсан. Мөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж харъяа дээд байгууллагаар батлуулаагүй, худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", 46 дугаар зүйлийн 46-д "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт хийлгүй худалдан авалт хийдэг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан харъяа дээд байгууллагаар батлуулаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнадаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан Дүрслэх урлагийн музейн Гадаад харилцаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга (Ц.Баттуяа)-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дүрслэх урлагийн музейн захирал (П.Байгалмаа)-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Э.МӨНХТОГТОХ